

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАР ДАХЬ МОНГОЛ УЛС, ОХУ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*С.Төмөр-Очир**

Эрхэм нөхөд өө!

Өнөөдөр та бид Монгол Оросын ард түмнүүдийн түүхэн харилцаанд шинэ хуудас нээж Монголын нийгмийн салбарт арилшгүй ул мөрөө үлдээж, шинэ цаг үед хэлбэр зохион байгуулалтын хувьд шинэчлэгдэн үйл ажиллагаагаа идэвхитэй явуулж буй МОКС-ын 60 жилийн ойг ахан дүүсийнхээ хамт тэмдэглэж байна.

Хоёр орны хамтын ажиллагаа нэвтрээгүй, соёлоор харилцах Монголын нийгэмлэгийн анхаарлын гадна байсан эдийн засаг, нийгэм, хүмүүнлэгийн нэг ч салбар байхгүй юм.

Хэдийгээр энэ байгууллага 1947 онд байгуулагдсан ч түүхэн улбаа, уламжлалаараа хэдэн зууны үйл ажиллагаа байсан гэж би боддог юм.

Ийм учраас би энэхүү илтгэлдээ боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт үүссэн, хөгжсөн ирээдүйд чиглэсэн бүх л чиглэл хандлагыг аль болох дэлгэрэнгүй авч үзэхийг хичээсэн билээ.

Цагийн хязгаарлалаас хамаарч та бүхэнтэйгээ илтгэлийн гол үзэл санаагаа тоймлон хуваалцахыг хүсч байна.

Монголын ард түмэн эрдэм мэдлэг, оюун ухааныг дээдэлж ирсэн түүхтэй билээ. Монгол, Орос хоёр улсын харилцаа нь боловсрол, соёл, шинжлэх ухаан зэрэг харилцааны гол салбарыг хамран идэвхитэй хөгжиж ирсэн байна.

Боловсролын салбар дахь хамтын ажиллагаа

1864 оны 11 дүгээр сарын 1-нд Хүрээнд Оросын консулын дэргэд хэлмэрч, орчуулагч бэлтгэх орос сургууль анх байгуулагдаж, тус сургуульд хоёр ч монгол багш монгол хэл зааж байсан тухай мэдээ байгаагаас үзвэл манай хоёр орны боловсролын салбар дахь хамтын ажиллагаа зуунаас хол давж буй нь ойлгомжтой байна. “Ургинская школа” хэмээн алдаршсан энэхүү Монгол дахь орос сургууль 56 жил болохдоо 100 гаруй хэлмэрч бэлтгэсэн байна. “Монгол, Манжуурын холбогдолтой олон улсын томоохон нэг ч гэрээ хэлэлцээр энэ сургууль төгсөгчдийн оролцоогүй болоогүй” гэж эрдэмтэн Р.Бямбаев бичсэн байна. 19-20 зуунд Монгол, Түвдээр аялсан Оросын бүх экспедицуудэд энэ сургууль төгсөгчид ажилласан байна.

1912 оны зун Хүрээн дэх Оросын консулын дэргэд хүүхдүүдэд зориулсан орос, монгол бага сургууль нээгджээ. Энэ сургуулийн анхны

* С.Төмөр-Очир- Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд, профессор

сурагчдын дотор Бат-Очир, Гүрсэд, Чойбалсан нар суралцаж байсан мэдээ буй. Бүрэн бус мэдээгээр 1919 он болоход Монголд 10 бага сургууль, 1 дунд сургууль ажиллаж байсан байна.

1911 онд Монгол Улс Манж Чин улсаас салж тусгаар тогтнолоо зарлав. Богдын засгийн газар европ маягийн сургууль байгуулахыг зорьж, улмаар 1912 оны 3 дугаар сарын 24-нд Монгол Улсын Гадаад хэргийн яамны дэргэд ерөнхий боловсролын анхны сургууль байгуулагджээ. Эл сургуульд эрдэмтэн Цэвээн Жамсран ажиллах болсон нь Монголын боловсрол хөгжихөд ихээхэн түлхэц үзүүлжээ.

Тухайн үед боловсрол олж авахын ач холбогдлыг эцэг эхчүүд, ард олонд таниулахдаа эзэн Чингисийн нэрийг хүртэл ашиглаж байсан нь сонин юм. “Шинэ толь” сэтгүүлийн 1914 оны 9 дүгээр дугаарт бичихдээ: “Монголын Чингис хаан, Хубилай хаан, Оросын нэгдүгээр Пётр хаан, Манжийн Энх-Амгалан хаан, Японы эзэн хаан Мацухито зэрэг агуу урирдагчид мэдлэгийг дэлгэрүүлэхэд нэгдүгээр зэргийн ач холбогдол өгч байсан юм” хэмээн тэмдэглэсэн байна.

Ийнхүү 1921 онд Монголын үндэсний ардчилсан хувьсгал ялж, Монгол дахь боловсролын асуудал шинэ шатанд гарлаа.

Ард олны гэгээрэл боловсролыг эмхлэн зохион байгуулж хөгжүүлэх нь маш хүнд зорилт байв. Тархай бутархай нүүдлийн мал аж ахуйтай манай орны хувьд тохирсон боловсролын системийг шинээр бий болгож ард түмний соёлын түвшинг дээшлүүлэхэд ихээхэн хүч, хөрөнгө шаардлагатай байв.

Хүн амыг бичиг үсэгт сургах, сургуулийн хичээл, хүмүүжлийн ажлын чиглэлийг зөв тогтоох явдал маш чухал байлаа. Энэ үед Зөвлөлтийн боловсролын системийн зохион байгуулалт, сургалтын системийг үлгэр жишээ болгон хэрэглээд зогсохгүй үндэсний багшлах боловсон хүчин бэлдэх хэрэгт ЗХУ-ыг түшиглэсэн юм.

Тухайн үед Монголын нутагт оршин сууж буй оросын иргэдийн хүүхдийг сургах сургуульд монгол хүүхдүүдийг сургаж эхэлсэн явдал нь ерөнхий боловсролын системийг бүрдүүлэхэд ихээхэн ач тус болжээ. Зөвлөлтийн сургуулиуд нь монгол сургуулиудад хичээлээс гадуур зохиогдох сургалт хүмүүжлийн ажил, дугуйланг зохион байгуулахад тусалж, сурах бичиг, сургалтын материаллаг бааз бий болгоход ихээхэн хувь оруулсан билээ. 1926 онд Монголд 11 зөвлөлтийн сургууль үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд 738 сурагч, 24 багштай байжээ. Эдгээр сургуульд 1926 онд 7 монгол хүүхэд сурч байсан байна. ЗХУ-ын Эрхүү болон Дээд Үд /Улаан Үд/ хотууд Монголын боловсролын салбарын боловсон хүчин бэлдэх гол төв болж байжээ. 1925 онд Эрхүүгийн их сургуульд 7, Дээд Үдэд 6 хүн суралцуулахаар явуулж байсан бол 1929-30 онуудад 51 болжээ. Эдний ихэнхи нь

ажилчин залуучуудын сургууль (рабфак), ерөнхий боловсролын сургууль буюу Эрхүүгийн их сургуулийн бэлтгэл ангид, цөөнх нь техникумд суралцаж байжээ. Москва, Ленинград хотод суралцахаар явсан монголчуудын тоо ч өсөж 1929 онд КУТВ-ийн үндсэн курст Монголын 116 хүн суралцаж байжээ.

1924 онд Ленинградын их сургуулийн Дорно дахины факультет болон багш, хоршоо, санхүүгийн сургуульд 10 хүн суралцаж байсан бол 1926 онд 80 гаруй болжээ. Чухамхүү эдний дотроос монголын анхны эрдэм шинжилгээний ажилтан нар төрөн гарсан юм.

Үндэсний боловсон хүчин бий болсон ба ЗХУ-аас олон тооны багш нар ирсэн явдал нь 1930 оноос БНМАУ-ын бага, дунд сургуулийг өргөтгөх боломжтой болгов. ЗХУ-ын тусламжтайгаар анхны 10 жилийн сургууль, уран сайхны, жолооч, уран дархны зэрэг бусад тусгай сургуулиудыг шинээр байгуулж, урьд байсан анагаах ухаан, мал эмнэлэг, санхүү, холбооны зэрэг тусгай мэргэжлийн сургуулийг өргөтгөн техникум болгожээ. Дээрхи сургуулиудад үзэх хичээлийн программ, сургалтын төлөвлөгөө, сурах бичгүүдийг ЗХУ-ын сургалтын системийн үлгэр загвараар боловсруулжээ.

Зөвлөлтийн сурган хүмүүжүүлэгч нар Монголд ажиллаж байх хугацаандаа сурган хүмүүжүүлэх ухааны онол, практикийн ач холбогдолтой ном зохиол туурвиж байжээ. Монголд нийтлэгдсэн сурган хүмүүжүүлэх ухааны анхны гарын авлага гурван дэвтэрийг А.И.Жарков, тоо заах арга, багш нарын лавлах бичгийг Л.И.Кузнецов нар бичсэн байна.

ЗХУ-д 1929 онд 370 хүн суралцаж байсан бол 1940 онд 739 болжээ. Зөвлөлтийн сургуулиудад суралцаж буй иргэдийн зардлын дөнгөж тал хувийг монголын засгийн газар гаргадаг байсан. ЗХУ-д суралцагчдын хэргийг БНМАУ-ын Ардын Гэгээрүүлэх яам эрхлэхээ больж ЗСБНХУ-ын Ардын Гэгээрүүлэх комиссар шууд хариуцах болжээ.

Монголын залуучуудыг сургах гол төв нь урьдын адил Дээд Үд, Эрхүү хот байв. Үүнд Дээд Үдийн монгол рабфак залуучуудыг сургах томоохон сургуулиудын нэг байжээ. Тэнд 1930 онд 168 хүн суралцаж байсан бол 1940 онд 199 хүн болж, арван жилийн дотор 32 хүн зөвлөлтийн дээд сургуульд, 112 хүн техникумд, 18 хүн Москвагийн тээврийн дээд сургуулийн дэргэдэх курст тус тус шилжин суралцжээ. БНМАУ-д ерөнхий боловсролын сургуулийн тоо хурдан өсч багшлах хүчин ихээхэн шаардлагатай болсонтой холбогдон 1940 онд монгол рабфакийг бага, дунд сургуулийн багш бэлтгэх чиглэлтэй болгон өөрчилжээ.

ЗСБНХУ, БНМАУ-ын засгийн газрын шийдвэрээр 1940 оноос БНМАУ-д зориулж багш бэлтгэх болсон Улаан-Үдийн багшийн сургуулийг Улаанбаатар хотын багшийн сургуультай 1941 оны 5

дугаар сард нэгтгэжээ. БНМАУ-д тусгай мэргэжлийн хүмүүсийг бэлтгэхэд Эрхүү хотын политехникум, хөдөө аж ахуй, анагаах ухаан, худалдааны техникум, Дорнод Сибирийн холбооны газрын дэргэдэх радио техникийн курс, авто замын техникум чухал үүрэг гүйцэтгэжээ. Эндээс радио, автомашин, барилга, уулын зэрэг техникийн мэргэжил бүхий хүмүүс, агрономич, зоотехникч, мал хүний бага эмч нар, худалдаа- санхүүгийн мэргэжилтэн нар бэлтгэгдэн гарчээ.

1932-34 онд Эрхүү хотын багш нар, санхүү-эдийн засаг, уулын дээд сургуулиудын дэргэдэх рабфакийг Монголоос 84 хүн төгсгөж дээд сургуульд орох бэлтгэлийг хангаж байжээ. Ер нь рабфак улс ардын аж ахуй, соёлын салбарт чухал хэрэгцээ шаардлагатай төрөл бүрийн боловсон хүчин бэлтгэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байсан байна.

Монголд боловсон хүчин бэлтгэх Монгол, Зөвлөлтийн хамтын ажиллагааны өөр нэгэн хэлбэр бол зөвлөлтийн мэргэжилтнийг дагалдуулан сургах явдал байжээ. Монголд ажиллаж байсан зөвлөлтийн мэргэжилтнүүд өөрийн мэргэжлийг монгол хүмүүст заавал сургах үүргийг өөрсдөө авч байлаа. 1937 онд Монголд ажилласан ЗХУ-ын усны нөөцийг судлах шинжилгээний анги 115 хүнийг худаг малтах, засах ажилд дагалдуулан сургажээ. 1936-1940 онд жолооч, засварчин, цахилгаанчин, токарчин зэрэг мэргэжилд 460 гаруй хүнийг дагалдуулан сургаж 217 хүний мэргэжлийн зэрэг ахиулжээ. Зөвлөлтийн мэргэжилтэн нар мэргэжилтэй ажилчин бэлтгэх, тэдэнд машин техник эзэмшүүлэх, мэргэжлийн дадлага олгох, мэдлэгийг нь ахиулах зэрэгт онцгой анхаарч байлаа.

1920-иод оноос эхлэн Монгол, Зөвлөлтийн хамтын ажиллагаанд харилцан дадлага хийх ба ажлын туршлага солилцох хэлбэр бий болж 1923 онд ЗХУ-аас хэлний бэлтгэл сайжруулахаар 3 оюутан ирж байсан бол 1934 онд Москва, Ленинградын Дорнодахины дээд сургуулийн монгол хэлний салбараас 1 жилийн хугацаагаар 31 оюутан ирж дадлага хийж байжээ. Үүний хамт Монголоос залуу ажилчид Зөвлөлтийн үйлдвэрийн газруудад очиж мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх дадлага хийдэг болжээ. Зөвхөн 1931 онд ЗСБНХУ-ын аж үйлдвэрийн газрууд 94 хүнийг дадлага хийлгэхээр хүлээн авсан байна.

Эх орны болон Халх голын дайны үед хэдий улс орны батлан хамгаалалтанд ихээхэн хөрөнгө зарцуулж байсан боловч эдийн засгийг хөгжүүлэх, соёлын бүтээн байгуулалтанд оруулах хөрөнгө жилээс жилд өсч байлаа. 1940 оноос 1945 онд БНМАУ-ын бүх төсвийн зарлага хоёр дахин өссөн байхад нийгэм-соёлыг хөгжүүлэх хэрэгцээний зардал гурав дахин нэмэгдсэн байна.

Монголын ард түмний түүхэнд тус орны нийслэл Улаанбаатар хотод улс орны сургалт, шинжлэх ухааны томоохон төв МУИС-ийг

1942 оны 10 дугаар сарын 5-нд нээсэн нь том үйл явдал болсон юм. Тус сургууль БНМАУ-ын улс ардын аж ахуй, соёлын бүх салбарыг хөгжүүлэхэд шаардагдах багш, хүн малын эмч, зоо техникч, инженер зэрэг мэргэжилтэй үндэсний боловсон хүчин бэлтгэх зорилтыг хангах ёстой байв. 1942 онд МУИС-д сурган хүмүүжүүлэх, анагаах ухаан, хөдөө аж ахуй гэсэн гурван факультетэд бүгд 100 шахам оюутан суралцаж байсан байна. БНМАУ-ын засгийн газрын шийдвэрээр Улсын их сургуулийн дэргэд политехникийн дээд сургууль, орос хэлний институт байгуулагдав. Их сургуульд эчнээ, оройн салбар, дээд мэргэжилтэн нарын мэргэжил дээшлүүлэх факультет ажиллаж байлаа. Их сургууль нь ЗХУ болон социалист бусад орны их дээд олон сургуулиудтай эрдэм шинжилгээний ба ажил хэргийн байнгын холбоотой ажиллаж байв.

Дэлхийн хоёрдугаар дайны үед БНМАУ-д зөвхөн хоёр дээд сургууль (МУИС, Намын дээд сургууль) байсан бол дайны дараа, ялангуяа 50-аад онд хэд хэдэн дээд сургууль шинээр байгуулагдав. Үүнд 1951 онд Багшийн дээд сургууль, тавиад оны эцэст Эдийн засгийн дээд сургууль, Хөдөө аж ахуйн дээд сургууль тус тус байгуулагдав. Эдгээр дээд сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлэхэд ЗХУ ихээхэн тусламж үзүүлжээ. 1958 онд Зөвлөлт засгийн газар МУИС-д эрдэм шинжилгээний том номын сан бэлэглэжээ. 1942-58 онд 160 гаруй зөвлөлтийн мэргэжилтэн багш нар ажиллаж байв. Их, дээд сургууль амжилттай хөгжиж, төрөл бүрийн мэргэжилтэй үндэсний сэхээтний эгнээ өргөжсөний дүнд 50-иад оны дунд үеэс их, дээд сургуулийн багшлах хүчнийг үндэсний боловсон хүчнээр хангах болов.

Боловсролын салбар дахь Монгол, Зөвлөлтийн хамтын ажиллагааны нэг үндсэн хэлбэр нь ЗХУ-ын их, дээд, тусгай мэргэжлийн сургуулиар монголын үндэсний боловсон хүчнийг бэлтгэх явдал байлаа. Монголын дээд сургуулиар 1960 он хүртэл эмч, багш, эдийн засагч, малын эмч, зоотехникч болон нам, улсын хариуцлагатай ажилтныг голчлон бэлтгэж байлаа. Уул уурхай, цахилгаан энерги, барилгын аж үйлдвэрийн мэргэжилтнүүдийг ЗХУ-д бэлтгэсэн нь аж үйлдвэрүүдэд ажиллах өндөр мэргэжилтэй боловсон хүчний хэрэгцээ, шаардлагыг хангахад чухал алхам болжээ. Үүний хамт ЗХУ-д боловсрол, соёл, урлагийн салбарын өндөр мэргэжилтэй боловсон хүчнийг бас бэлтгэж байв. 1946-1960 он хүртэл ЗХУ-ын их дээд сургуулиар монголын 600 гаруй мэргэжилтэн бэлтгэгдэн гарчээ. Мөн ерөнхий боловсролын сургуулиудыг үйлдвэр сургалттай, хөдөлмөр политехникийн сургууль болгон өөрчлөн байгуулах талаар 50-аад оны эцсээс эхэлсэн ажилд зөвлөлтийн боловсролын туршлага чухал үлгэр жишээ болсон юм.

1960-70-аад онуудад БНМАУ-ын Гэгээрлийн яам Зөвлөлтийн мэргэжилтэн багш нарыг урьж ирүүлсэн нь Монголын ерөнхий боловсролын сургуулиудыг өөрчлөх хэрэгт их тусламж үзүүлсэн байна. 1963 оны гуравдугаар сард БНМАУ-ын Ардын Их Хурлын IV чуулган “Сургууль амьдралын холбоог сайжруулж, ардын боловсролын системийг цаашил хөгжүүлэх тухай” хууль батлав. Хуулиар долоон жилийн сургуулийг найман жилийнх болгох зэргээр ерөнхий боловсролын сургуулиудын зохион байгуулалтанд зарим өөрчлөлт оруулжээ. 1961-1971 онд БНМАУ-д ерөнхий боловсролын сургууль 223-ыг шинээр байгуулсан, үүний 60-аас дээш хувь нь дунд сургууль байв.

Дээд ба тусгай мэргэжлийн боловсролын хувьд 1973 оны есдүгээр сарын 14-нд ЗХУ-ын Дээд ба тусгай дунд боловсролын яам, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Дээд ба тусгай дунд боловсролын улсын хороо хоёр дээд ба тусгай дунд боловсролын талаар шууд хамтран ажиллах 10 жилийн хугацаатай хэлэлцээр байгуулав. 1976-1980 онд монголчуудын дунд орос хэл, уран зохиол судлах талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулав. Уг хэлэлцээр ёсоор ЗХУ-ын их, дээд сургуулиудад монгол сургуулиудын орос хэлний багш нарыг “орос хэл, уран зохиолын” мэргэжлээр бэлтгэж байв. БНМАУ-ын дотоодод орос хэлний багш нар бэлтгэхэд ЗХУ орос хэл, уран зохиол, заах аргын мэргэжилтнүүд ирүүлж тусалж байхаар тохиролцсон байна.

1977-78 оны байдлаар 14-40 хүртэлх насны хүмүүсийн 70% нь ямар нэгэн шатны боловсрол эзэмшсэн байна. Эдгээр онуудад монгол оюутны нийт тоо 17.8 мянгад хүрч 10 мянган хүн тутамд 116 оюутан ногдох болжээ. Мөн улс ардын аж ахуйд ажиллаж байгаа 1000 хүн тутмаас 139 нь дээд, дунд боловсролтой хүмүүс байжээ.

Боловсролын салбарт ЗХУ-ын тусламж улам өргөсч, Москва, Ленинград, Киев, Эрхүү зэрэг хотуудын их дээд сургуулиудад монголын олон тооны инженер техникийн мэргэжилтнүүдийг бэлтгэж өгсөн бөгөөд Улаанбаатар хотын МУИС-ийн дэргэд политехникийн дээд сургууль, анагаах ухааны дээд сургууль, аймгуудад хэд хэдэн техникум байгуулахад тусалж, хэрэгцээтэй тоног төхөөрөмж, хичээлийн хэрэгслэл, сурах бичиг нийлүүлж, туршлагатай багш нараа ирүүлсэн байна.

Үйлдвэрлэл-техникийн боловсролын системд монгол ажилчдыг бэлтгэх явдал чухал суурь эзэлж байлаа. БНМАУ жил бүр олон мянган охид хөвгүүдийг зөвлөлтийн техник мэргэжлийн сургуульд суралцуулахаар явуулж байв. Зөвхөн 1964-65 онд зөвлөлтийн техник-мэргэжлийн сургуулиуд БНМАУ-д 2100 мэргэжилтэй ажилчдыг бэлтгэж өгсөн бөгөөд 1966 онд 1000 монгол залуусыг суралцуулахаар хүлээн авч байжээ. Тэд Чимкентийн фосфорын давсны завод, Джамбулын

суперфосфатын завод, Ленинградын хөнгөн цагааны заводуудад үйлдвэрлэлийн дадлага хийжээ.

Монгол, Зөвлөлтийн боловсролын ба боловсон хүчин бэлтгэх салбарын харилцаа холбоог зохицуулж байсан бүх баримт бичгүүд энэ салбар дахь Монгол, Зөвлөлтийн хамтын ажиллагааны хир хэмжээг тодорхой харуулж байлаа. Энэ хамтын ажиллагаа нь удаан хугацаатай, төлөвлөгөөтэй явагддаг байсан ба хоёр орны хэрэгцээ шаардлага, нөхцөл бололцоог нарийн тооцсон шинжлэх ухааны үндэслэлтэй зэрэг шинэ онцлогтой байв.

1980-аад оны сүүлээр ЗХУ-ын их, дээд сургуулиудад 10000-с дээш хүн суралцаж байжээ. Нийтдээ 1921-1990 онуудад 55000 гаруй монгол хүн ЗХУ-д боловсрол эзэмшсэн гэсэн тоо байдаг.

1990 оноос хойш хоёр орон зах зээлийн харилцаанд орсноор шилжилтийн үеийн хүнд байдалд боловсрол, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагаа түр зур зогсонги байдалд оров. Энэ үеэс эхлэн өнгөрсөн үеийн харилцаанд дүн шинжилгээ хийж, шинэ орчин нөхцөлд үүсэж буй харилцааны эрх зүйн үндэсийг шинэчлэх шаардлага гарч ирлээ. Эдгээр зорилтууд хоёр талын идэвхитэй хамтын ажиллагааны тусламжтайгаар шийдвэрлэгдэж байна. 1993 онд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатын ОХУ-д албан ёсны айлчлал хийх үед гарын үсэг зурсан Гэрээний дагуу 1994 оноос ОХУ өөрийн хөрөнгөөр монголын 20 оюутан, 5 аспирантыг сургаж эхэлжээ. Дараа дараачийн жилүүдэд энэ тоо хэд хэд өссөн бөгөөд өнөөдрийн байдлаар 1400 гаруй хүн, тэдгээрийн 80% нь оюутан, ОХУ-д суралцаж байна.

Соёл, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбарын уламжлалт харилцаа зах зээлийн нөхцөлд зохицон хөгжиж байна. ОХУ-д жил бүр 200-аад оюутан, аспирант Оросын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр болон Засгийн газар хоорондын хэлэлцээрээр их, дээд сургуулиудад элсэн, Монголын олон зуун иргэн хувиараа буюу аж ахуйн байгууллагуудын зардлаар суралцаж байна. Өнөөгийн байдлаар Улаанбаатарт Москвагийн Эрчим хүчний их сургууль, Багшийн их сургууль, Плехановын нэрэмжит Эдийн засгийн Академи, Дорнод Сибирийн Хүнсний технологийн дээд сургууль, Буриад, Кемеровын улсын их сургуулиудын салбарууд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд манай нийслэл, бусад хот суурин газруудад цөөнгүй тоогоор байгуулагдсан орос хэл дээр сургалттай бага, дунд сургууль, цэцэрлэгүүдийн хамт манай боловсролын тогтолцоонд байр сууриа эзэлжээ.

2003 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-д айлчлах үеэр 2 чухал баримт бичигт гарын үсэг зурсан нь “Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын Засгийн газрын хооронд соёл, шинжлэх ухааны салбарт 2003-2006 он хүртэл хамтран ажиллах хөтөлбөр”, мөн

“Монгол Улсын Засгийн Газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд боловсролын баримт бичиг, эрдмийн зэрэг, эрдмийн цол харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр” зэрэг байлаа. Эдгээр баримтаас үүдэн Монголд эзэмшсэн боловсролын гэрчилгээ, диплом зэрэг нь ОХУ-д хүлээн зөвшөөрөгдөх болов.

Шинэ 12 жилийн сургалтын агуулгад орос хэлийг заавал үзэх албан ёсны хичээл болгон оруулж байна. Орос хэлний сургалтын агуулга, арга зүйн багш нарыг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэхэд ОХУ-ын зүгээс бодитой тусалцаа үзүүлнэ гэдэгт бид итгэж байна.

Соёлын салбар дахь хамтын ажиллагаа

Хоёр орон, ард түмний харилцаа нь соёл урлагийн салбарт өвөрмөцөөр илэрдэг билээ.

Хил залгаа оршсоор ирсэн хоёр орны ард түмэн үеэс үед найрсаг харилцаатай байсны уламжлалыг эв модны наадам зохиож ирсэн түүхээс бид мэдэж байна. Энэхүү уламжлал ардын хувьсгалын дараа улам идэвхитэй өрнөх болсны нэгэн жишээ бол 1921 оны 10 дугаар сард Нийслэл хүрээнд нээгдсэн “Нардом” хэмээн нэрлэгдсэн “Народный дом” нь орос, монголын авьяас билэгтэн нарын санал сэтгэлээ нээлцдэг газар болж, хамтарсан үдэшлэг, урлагийн тоглолт хийж, сүүдэр ший кино үзүүлж, ший жүжиг найруулан тавьдаг соёлын төв болж байв. Үүний зэрэгцээ 1924 онд “Сүхбаатарын нэрэмжит клуб” нээгдсэн нь тухай үедээ соёл гэгээрэл, урлаг уран сайхны гол төв болж байжээ. Тэнд хоёр орны ёслолын чуулган, лекц яриа болж, үзэсгэлэн гарч, биеийн тамирын төрөл бүрийн тэмцээн наадам зохиогдож Монголын төв хөдөөд соёл урлагийн үр шимийг түгээх талбар болж байв. Улаанбаатар хотод төдийгүй хөдөө орон нутагт соёлын голомтыг байгуулах үйлсэд орос, монгол хүмүүсийн хамтын хүчин чармайлт ач тусаа хүргэсэн юм.

Театр, кино, хэвлэл, номын сан, музейн материал техникийн баазыг буй болгож бэхжүүлэхэд тухайн үеийн ЗХУ их тусламж үзүүлэв.

Уудам дэлгэр нутагтай, хүн ам сийрэг, нүүдэлчин амьдрал үргэлжилсэн оронд радио шугам бий болгох нь тулгамдсан асуудлын нэг байлаа. 1933 оны хоёрдугаар сарын 9-нд Монгол, Зөвлөлтийн хооронд БНМАУ-ыг радиожуулах тухай гэрээ байгуулсан нь чухал үйл явдал болжээ. Уг гэрээ ёсоор 1934 онд ЗХУ-ын тусламжтайгаар Улаанбаатар хот, аймгуудын төв, зарим суурин газарт 20 гаруй богино долгион хүлээн авагчийг ашиглалтанд оруулж, тогтмол радио нэвтрүүлэг явагдах болов.

1967 онд ЗХУ-ын тусламжтайгаар телевизийн төв, мөн Орбита станцыг барьж ашиглалтанд оруулсан нь Монголын ард түмний соёлын амьдралд гарсан том дэвшил болов.

Материаллаг баазын хувьд байнга бэхжиж ирсэн соёл урлагийн салбарт тухай тухайн үеийн үзэгч, сонсогч, уншигчдын хэрэгцээг хангахад, соёл урлаг, утга зохиолын цаашдын хөгжилд Монголд ажиллаж амьдарч байсан, мөн урт богино хугацааны томилолтоор ирсэн хүмүүс мэргэжилтнүүд чухал үүрэг гүйцэтгэснийг бид мартаж өгсгүй. Үүнд театрын урлагт А.Ефремов, В.Борейшо, Г.Уварова, кино урлагт С.Гусев, И.Трауберг, Ю.Тарич, циркийн урлагт А.Волошин, хөгжмийн урлагт Ц.Сампилов, К.Померанцев, утга зохиолд З.Зазубрин, М.Булышев, соёл урлагийн мэргэжилтэн сурган бэлтгэхэд К.Никитин зэрэг олон арван авъяас билэгтнүүд үр бүтээлтэй ажиллаж монгол залуусыг соёл урлагийн салбарт өсөж дэвшихэд сайхан бололцоо олгосныг манай ахмад дунд үеийн уран бүтээлчид бахархан дурсаж байдаг юм.

Хоёр орны уран бүтээлчдийн хамтын ажиллагааны туршлага зузаарч олон хэлбэр хэлбэршин тогтов. Ялангуяа хамтарч уран бүтээл хийх нь хамтын ажиллагааны нэгэн чухал хэлбэр болсон юм.

1935 оны наймдугаар сард Улсын Төв театр, Зөвлөлтийн киноны байгууллагын хооронд хувьсгалын 15 жилийн ойд зориулж кино хамтран бүтээх тухай тусгай хэлэлцээр байгуулжээ. Уг хэлэлцээрийн ёсоор 1936 онд “Монгол хүү” хэмээх уран сайхны дуутай киног монгол, орос хэлээр хийжээ. Монголын үзэгчид анх удаа кино дэлгэцнээ монгол жүжигчид тоглохыг харж төрөлх хэлээрээ ярилцахыг үзэж их хөөр бахдал болсон бөгөөд ЗХУ болон АНУ зэрэг дэлхийн бусад оронд ч энэ кино бас их амжилт олсон байна. Энэ уламжлал үргэлжилж “Сүхбаатар”, “Дайсны цэргүүдээ сонсоцгоо”, “Говь Хянганд тулалдсан нь” зэрэг кино хоёр орны уран бүтээлчдийн хамтын ажиллагааны үр дүн мөн.

Монголчуудын соёлжин гэгээрэхэд утга зохиолын үүрэг үлэмж. Монголын тал А.М.Горькийн зөвлөснөөр “идэвхитэй зарчмыг сурталчилсан” эрх чөлөө, шударга үзлийг удирдлага болгодог хүний баатарлаг үйлсийг хамгийн хурц тод харуулсан дэлхийн болон орос, зөвлөлтийн сонгодог бүтээлийг юуны түрүүнд монгол хэлээр орчуулах болжээ. А.С.Пушкин, Н.В.Гоголь, Л.Н.Толстой, М.Салтыков-Щедрин, И.С.Тургенев, А.Чехов, А.Некрасов, И.Крылов, М.Горькийн зарим зохиолууд монгол хэлнээ орчуулагдан нийтлэгджээ. Монголын утга зохиолын номын сан цувралаар 1981-88 онд 16 ботийг орос хэлээр орчуулж Москвад хэвлэсэн нь Монголын уран сайхны соёлыг европ дахин цаашилбал дэлхийд түгээн сурталчилахад шинэ үе шат болсон юм.

Монгол Улс, ОХУ-ын соёлын уламжлалт хамтын ажиллагаа шинэ нөхцөлд, шинэ агуулга, хэлбэрээр баяжин хөгжиж байна. Соёлын харилцаа, хамтын ажиллагаа нь манай хоёр улсын иргэдийн сэтгэлгээний болон бүтээн туурвих, үр шимийг нь хүртэх эрх, эрх чөлөөг хангах, авъяас чадвараа илрүүлж, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд тус дөхөм болж байна.

Энэ үйл явц манай ард түмнүүдийн соёл харилцан баяжихад дөхөм үзүүлэх, томоохон хэмжээний уран бүтээл хамтран туурвих, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, соёлын үйл ажиллагааны туршлагаа солилцох, хамтарсан хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр идэвхитэй, үр өгөөжтэй хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх чиглэлээр өрнөж байна.

Монгол Улс, ОХУ-ын төр, засгийн тэргүүнүүдийн харилцан айлчлал, соёлоор хамтран ажиллах тухай байгуулсан шинэ гэрээ, протоколын үр дүнд манай хоёр улсын соёлын амьдралд чухал тэмдэглэлт үйл явдлууд өрнөлөө. Тухайлбал, сүүлийн 20 гаруй жил тасраад байсан ОХУ-ын соёлын өдрүүдийг 2002 онд Монгол Улсад, Монгол Улсын соёлын өдрүүдийг 2003 онд ОХУ-д амжилттай зохион байгууллаа. ОХУ-ын их, дээд сургуулиуд соёл, урлагийн менежер, найруулагч, хөгжимчин, кино оператор, дуулаач, номын санч зэрэг чиглэлээр аспирантур, докторантур, магистрын болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд 100 шахам хүн хамрагдаад байна. Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Холбооны соёл, кино урлагийн агентлаг хамтын ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна.

Хоёр улсын хил орчмын аймаг, муж, районы соёлын шууд харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц идэвхжин хөгжиж байна. Цаашид бид хоёр улсын соёлын харилцааг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор улам өргөжүүлэн хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

90-ээд оноос хойш нэг хэсэг зогсонги байдалд орсон манай хоёр орны соёлын харилцаа сүүлийн жилүүдэд идэвхжин зах зээлийн нөхцөлд зохицон хөгжиж байна. Энэ үйл явдал нь монголчуудын талархлыг хүлээж байна.

Шинжлэх ухааны салбар дахь хамтын ажиллагаа.

Шинжлэх ухааны салбар дахь Монгол, Зөвлөлтийн хамтын ажиллагаа нь манай улсад эрдэм шинжилгээний боловсон хүчин бэлтгэх, шинжилгээ, судалгааны байгууллагуудыг зохион байгуулах, Монгол орны байгалийн баялаг, эрдэс түүхийн эдийн нөөцийг судлах талаар хоёр улсын хооронд байгуулагдсан гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр гүнзгийрэн хөгжиж ирсэн билээ.

1920-оод оноос Зөвлөлтийн эрдэм шинжилгээний олон экспедиц Монгол улсад ирж ажилласан байна. 1923-1928 онд ургамал судлалын хээрийн судалгааны анги манай орны хангайн бүс, говийн хойт хэсгээр судалгаа явуулж арвин их материал цуглуулсан байна. Хөрс судлаачид Хэнтийн дундад хэсэг, Жаргалант, Дөхөм нуурын орчим тал, говийн хойт зах, Хангайн нурууны зүүн хэсэг, Орхон голын эх, Орхон-Сэлэнгийн бэлчирийг шинжилж, эндхийн хөрсний геоморфологийн тогтоц, газрын хотгор, гүдгэр, ургамлын өөрчлөлтийг тодорхойлсон байна. Амьтны аймгийг судлах ангийнхан Хангайн нурууны өвөр, Говь-Алтайн нуруудын хөндий ба Говь-Алтайн уулсын хөхтөн, жигүүртэнг судалж, тодорхойлолт хийсний зэрэгцээ хөхтөн амьтдын орших газар, тархацын тухай бичиж, Монгол орныг амьтан, газар зүйн талаар мужилсан байна. Геологийн анги Монголын баруун, зүүн хэсэгт ажиллаж, түүний геологийн тогтоцыг тодорхойлж, үнэт чулуу элбэгтэйг тэмдэглэж хэд хэдэн ашигт малтмалын ордыг нээж, Онон-Хэрлэнгийн сав газрын геологийн зургийг зохиосон байна. 1926-28 онд Монголын нуур, рашаан усны химийн судалгаа хийж манай орны рашааны тухай анхны судалгааны бүтээлүүд туурвижээ. Шинжилгээний анги Хэнтийн уул, Хэрлэн, Туул, Сэлэнгийн сав газраар хайгуул, шинжилгээний ажил хийж баруун, зүүн хэрэм хэмээх балгасуудыг анх илрүүлсний дээр шинжлэх ухаанд мэдэгдээгүй байсан Туркийн хэд хэдэн булш олжээ. Эдгээр шинжилгээний ангийн ажлын үр дүн нь “Буриад АССР, Тагна Тува, БНМАУ-ын шинжилгээний комиссын материал” хэмээх цуврал бүтээлээр хэвлэгдэн гарсан бөгөөд Монгол Улсыг цаашид судлах явцад чухал ач холбогдолтой материал болсон байна.

1924 оны 11 дүгээр сарын 17-нд хоёр орны эрдэм шинжилгээний төвүүд түүх, археологийн дурсгалыг судлах Оросын газар зүйн нийгэмлэгийн П.К.Козлов тэргүүтэй эрдэм шинжилгээний ангийн ажлын тухай гэрээ байгуулжээ. Шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд эртний судлал, ургамал амьтан, эрдэс зүйн мэргэжилтнүүд оролцсон байна. Энэ экспедиц Монголд 3 (1923-1926) жил ажиллаж цаг уур, геологи, ургамал судлал, амьтан судлал, шувуу судлалын талаар баялаг материал цуглуулжээ. Тус шинжилгээний анги Ноён ууланд хүннүгийн үеийн хэд хэдэн том булшийг малтан 2 мянган жилийн тэртээд Төв Азид оршин суугчдын соёл иргэншлийн байдлыг тусгасан ховор нандин олдвор илрүүлсэн нь ХХ зууны археологийн гайхамшигт нээлтийн нэгэн болсон байна.

1926 оны 7 дугаар сарын 5-нд БНМАУ-ын Судар бичгийн хүрээлэн, ЗСБНХУ-ын ШУА-ийн дэргэдэх монгол судлалын комиссын хооронд эрдэм шинжилгээний талаар хамтран ажиллаж, ЗХУ-аас Монгол орныг шинжлэн судлах, Монголын шинжлэх ухааныг

хөгжүүлэхэд туслах зорилгоор Монголд эрдэм шинжилгээний ангиудыг зохион байгуулан ажиллуулах тухай хэлэлцээр байгуулжээ. Хэлэлцээр ёсоор Зөвлөлтийн ШУА-ийн Монголын Комисс Монголыг шинжлэн судлахаар 8 экспедиц явуулах, тэдгээрийн 6 нь Монгол орны дунд бүсээр, 2 нь Монголын баруун хязгаарын Улиастай, Ховд хотын чиглэлд ажиллахаар тохиролцсон байна.

1930-1934 онд геологи, геохими, палеонтологи, гидрогеологи, хөрс, ургамал, зоологи, археологи, антропологи, хэл шинжлэлийн 11 ангийг Монголд ажиллуулахаар тохиролцсоны дагуу тус орны хөрс, ургамал, амьтан, газар зүй, ус, геологи, цаг уур, ой мод, эдийн засаг, түүх, эртний судлал, хүн амын зан заншил, хэл аялгуу зэргийг судлах чиглэлээр хамтын шинжилгээний ангиуд зохион байгуулагджээ.

Монгол, Зөвлөлтийн шинжлэх ухааны хамтын ажиллагааны цаашдын хөгжил нь манай орны хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйг судлахад гол анхаарлаа хандуулав. ЗХУ-ын ШУА-иас шинжилгээний ангиудыг Монголд удаа дараа ирүүлж 5 хошуу малын мах сүү тосны гарцыг судалжээ. Монголын мал аж ахуйг хөгжүүлэхэд байгалийн бэлчээр, тэжээлийн ургамлыг судлах нь нэн ач холбогдолтой байсныг харгалзан 1930 онд эхэлсэн ЗХУ-ын ШУА, Монголын Шинжлэх ухааны хүрээлэнгийн хамтарсан шинжилгээний анги манай орны ургамлын ихэнхи төрлийг илрүүлжээ.

Түүнчлэн Монгол орны хөрсийг судлах ажил амжилттай өрнөж 1940 он гэхэд газар тариалан хөгжүүлж болох газрын зургийг зохиож, Монгол оронд үр тарианы аж ахуй хөгжүүлэх өргөн боломж байгааг нотолсон билээ. Мөн 1933-1935 онд ус, усны хангамжийн судалгаа хийсэн байна. Энэхүү ажлын үр дүнд Монгол орны усны нөөцийн үлэмж хэсэг нь газрын хөрсөн дор байгааг нотлон худгийн тоог олшруулах замаар хүн ам, малыг ундны усаар бүрэн хангах боломжтой гэж үзсэн байна.

Мал аж ахуй зонхилсон Монгол орны тухайд чухал шаардлагатай байсан цаг уурын судалгааг хоёр орны шинжлэх ухааны байгууллагууд хамтран амжилттай хөгжүүлсэн байна.

Ийнхүү тасралтгүй хөгжиж ирсэн манай хоёр улсын шинжлэх ухааны салбар дахь хамтын ажиллагаа 60, 70-аад оноос улам өргөн тэлж хамтын судалгааны иж бүрэн экспедицууд явуулж байгаагийн зэрэгцээ олон тооны сэдвийн хүрээнд хоёр орны эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиуд хамтран ажиллах болсон билээ. Өнөөгийн байдлаар Монгол Улсын ШУА ОХУ-ын ШУА-ийн 30 гаруй хүрээлэн төв, их сургуулиудтай экологи, газар зүй, цэвдэг судлал, одон орон, ургамал, амьтан судлал болон эрдэмтэн судлаач бэлтгэх чиглэлүүдээр хамтран ажиллаж байна.

2005 оны 9 дүгээр сард хоёр орны ШУА-ийн тэргүүн нар Орос, Монголын Шинжлэх ухаан академи хоорондын хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурж, 2006-2010 онд шинжлэх ухааны талаар хамтран ажиллах сэдэвчилсэн төлөвлөгөөг баталсан билээ. Энэ төлөвлөгөөний дагуу хоёр талын ШУА-ийн холбогдох байгуулагууд хамтын ажиллагаагаа сэргээн хөгжүүлж байна. Тухайлбал, хоёр талын холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын хүчээр Орос-Монголын хамтарсан биологийн экспедиц, геологийн экспедиц, гео-физикийн экспедиц, түүх, соёлыг судлах экспедиц амжилттай ажиллаж байна. Түүнчлэн хими, физик, биологи, геологи, ургамал, амьтан судлал, газар зүй, геоэкологи, хэл зохиол зэрэг 16 чиглэлээр 85 сэдвийн хүрээнд хамтарсан судалгаа явуулж байна.

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Оросын Хүмүүнлэгийн ухааны сан, Суурь судалгааны сантай хамтран ажиллах гэрээ байгуулж, 2006 оноос эхлэн хоёр талын хамтарсан санхүүжилтээр байгаль, нийгмийн ухааны чиглэлээр 50 гаруй төслийн хүрээнд хамтарсан судалгаа явуулж байна. Энэ ажил цаашид улам өргөжих болно.

Манай хоёр орны хөгжлийн чанарын шинэ дэвшлийг авчирсан он жилүүд нэгэнт эхэлж төрийн тэргүүнүүд энэ харилцаанд онцгой үүрэг гүйцэтгэж байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2000 онд Монгол Улсад, 2006 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-д албан ёсны айлчлал хийв. Уг айлчлалуудын хүрээнд хоёр улсын төрийн тэргүүн нар Монгол, Оросын харилцааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх асуудлыг хэлэлцэж, олон талын асуудлаар санал солилцож, Улаанбаатар болон Москвагийн тунхаглалд гарын үсэг зурсан. Москвагийн тунхаглалд “Хоёр орны ард түмний оюун санааны болон соёлын ойр дотно уламжлалт хэлхээ холбоог хадгалан бэхжүүлэхийн төлөө байдаг, Монгол Улс, ОХУ нь ОХУ-ын их, дээд сургуульд суралцаж байгаа монгол оюутны тоог нэмэх, мэргэжилтэн бэлтгэх, давтан бэлтгэх, сургалтын хөтөлбөр солилцох замаар хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах болно. Монгол Улсад орос хэлийг, Орос улсад монгол хэлийг сурах, судлахыг хөхиүлэн дэмжих болно” хэмээн тунхаглажээ.

Сайн хөршийн найрсаг харилцааг дэмжиж, түүнийг бүх талаар хөхиүлэн дэмжих явдал хоёр орны хувьд ихээхэн ач холбогдолтой явж ирсэн бөгөөд цаашид ч ийм байх нь дамжиггүй.

Анхаарал тавьсанд баярлалаа.